



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2015 оны 02 сарын 12 өдөр

Дугаар 96

Улаанбаатар хот

“Монре даатгал” ХХК-ийн эрх бүхий албан тушаалтныг томилохыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.3, Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.1, Даатгалын тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монре даатгал” ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар Пүрэвжав овогтой Эрдэнэбаатарыг томилохыг зөвшөөрсүгэй.
2. Хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж, даатгуулагчдын эрх ашгийг дээдлэн ажиллахыг П.Эрдэнэбаатарт үүрэг болгосугай.
3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Ц.Энхбаяр/-нд даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА

000642